



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 127

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр бүлгийн 4.3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 84 дүгээр тогтоол, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам, “Монгол дээвэр” ХХК-тай 2020 онд байгуулсан ажлын нэмэлт гэрээ, Барилга угсралтын ажлын захиалагч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч, гүйцэтгэгчийн хамтарсан хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэмэлт санхүүжилтээр хийгдсэн 307,798,589 /гурван зуун долоон сая долоон зуун ерэн найман мянга таван зуун наян ес/ төгрөгийг Сайнцагаан сумын Наймдугаар цэцэрлэгийн барилга, үл хөдлөх хөрөнгийн дансанд нэмж бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Сайнцагаан сумын Наймдугаар цэцэрлэгийн эрхлэгч (Л.Оюун)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын
24-ний өдрийн 127 дугаар тогтоолын хавсралт



**Сайнцагаан сум Наймдугаар цэцэрлэгийн үл хөдлөх хөрөнгөд
нэмж бүртгэх хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	2020 онд бүртгэлд авсан барилгын дүн	Барилгад нэмж бүртгэх дүн
4	Цэцэрлэгийн барилга	741,358,340	307,798,589
Барилга байгууламжийн нийт дүн		1,049,156,929 /Нэг тэр бум дөчин есөн сая нэг зуун тавин зургаан мянга есөн зуун хорин есөн төгрөг/	